



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Г Засгийн газрын Үндэсний хороо, комисс, Г Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Агаарын тухай хуулийн 6.1.2, 6.2, Автотээврийн тухай хуулийн 5.1.6, Аялал жуулчлалын тухай хуулийн 20.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.2, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.3, 22.9, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14.3, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.2, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³.6, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22.1, 22.2, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 11.3, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.6, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹.1, Боловсролын ерөнхий хуулийн 23.3, 24.1.9, Оюуны өмчийн тухай хуулийн 10.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.9, Усны тухай хуулийн 9¹.3, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 15.1.3, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41.2, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 8.3, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 4.1.3, Хүнсний тухай хуулийн 18.4, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.1, 16.2, Хэмжил зүйн тухай хуулийн 18.2, Цөмийн энергийн тухай хуулийн 10.3, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6.1, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 3 дугаар, Боловсролын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 5 дугаар, Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 6 дугаар, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 дугаар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 8 дугаар, Допингийн эсрэг үндэсний зөвлөл (платформ)-ийн бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 10 дугаар, Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 11 дүгээр, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 12 дугаар, Замын хөдөлгөөний

аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 13 дугаар, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 14 дүгээр, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 15 дугаар, Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 16 дугаар, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 17 дугаар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 18 дугаар, Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 19 дүгээр, Олимп, паралимпын наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг зохион байгуулалтаар хангах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 20 дугаар, Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 21 дүгээр, Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 22 дугаар, Сансрын бодлогын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 23 дугаар, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 24 дүгээр, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг 25 дугаар, Усны үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 26 дугаар, Уур амьсгалын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 27 дугаар, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 28 дугаар, Үндэсний тээврийн хорооны бүрэлдэхүүнийг 29 дүгээр, Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 30 дугаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 31 дүгээр, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 32 дугаар, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулан зохион байгуулах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 33 дугаар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 34 дүгээр, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 35 дугаар, Хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 36 дугаар, Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг 37 дугаар, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 38 дугаар, "Шинэ хархорум" хотын бүтээн байгуулалтын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 39 дүгээр, Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах Засгийн газрын комисс, хороо, тэдгээрийн даргыг 40 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт, эсхүл холбогдох бусад хууль тогтоожид тусгайлан заасны дагуу байгуулагдсан болон энэ тогтоолын 1-д зааснаас бусад Засгийн газрын тогтоолоор байгуулсан үндэсний хороо, комисс, зөвлөлийг татан буулгасугай.

3.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан Хүний эрхийг хангах үндэсний хорооны чиг үүргийг Төрийн бүтээмжийн үндэсний хороонд шилжүүлэн, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны Ажлын албаны орон тооны хязгаарыг 15 байхаар тогтоож, түүний үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "20 минутын хот Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, Сайдын Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "20 минутын хот Үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ий Гишүүд хэсэгт "Гишүүд:" гэсний дараа "Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан (зөвшилцсөнөөр);" гэж нэмсүгэй.

5.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай” Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 234 дүгээр тогтоолын 4 дэх заалтын “хамтран ажиллахыг” гэсний дараа “Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн,” гэж нэмж, мөн тогтоолын 2 дахь заалтын “Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт” гэснийг “Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэнд” гэж өөрчилсүгэй.

6.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд даалгасугай.

7.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоол, “Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг батлах, тогтоолд нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 295 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

Васгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэд дарга: -Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга
- Гишүүд: -Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/-ын Ажлын албаны дарга;

-Монгол Улсын Шадар сайд /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/-ын Ажлын албаны дарга;

-Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны дарга;

-20 минутын хот Үндэсний хорооны Ажлын албаны дарга;

-Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албаны дарга.

Нарийн бичгийн дарга:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Архив, нууц, албан хэрэг хөтлөлтийн хэлтсийн дарга;

-Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга.

---o0o---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ САНГИЙН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Гишүүд:
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл Монгол хүн” төсөл, хөтөлбөр хариуцсан Албаны дарга (тохиролцсоноор);
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;
 - Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга;
 - Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга;
 - Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга;
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга;
 - Олон нийтийн төлөөлөл (Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал);
 - Олон нийтийн төлөөлөл (Монголын хүнсчдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал);
 - Олон нийтийн төлөөлөл (Монголын хүнсчдийн нэгдсэн холбооны Исгэлтийн үйлдвэрлэлийн салбар хариуцсан Дэд ерөнхийлөгч);
 - Олон нийтийн төлөөлөл (Монголын хүнсчдийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Арвайн үндэс” ХХК-ийн гүйцэтгэх захирал);
 - Олон нийтийн төлөөлөл (Монголын хүнсчдийн нэгдсэн холбооны гишүүн, “Жем интернэйшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирал);

-Олон нийтийн төлөөлөл (Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Удирдах зөвлөлийн гишүүн, "АПУ" ХК-ийн гүйцэтгэх захирал);

-Олон нийтийн төлөөлөл (Европ, Монголын хамтарсан худалдаа, аж үйлдвэрийн танхимын "Хүнс, ундааны ажлын хэсэг"-ийн гишүүн, "Сирм" ХХК-ийн гүйцэтгэх захирал);

-Олон нийтийн төлөөлөл ("Монголын донтох эмгэг судлаачдын нийгэмлэг" ТББ).

Нарийн бичгийн
дарга:

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

---oOo---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Гишүүд:
- Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
 - Монгол Улсын Шадар сайд /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/;
 - Сангийн сайд;
 - Хууль зүй, дотоод хэргийн сайд;
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
 - Зам, тээврийн сайд;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
 - Эрчим хүчний сайд;
 - Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
 - Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал;
 - “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо”-ны ерөнхийлөгч;
 - “Жуулчны баазуудын холбоо” ТББ-ын тэргүүн (Нийтийн эрх зүйн хуулийн этгээд санал болгосноор);
 - “Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо” ТББ-ын тэргүүн (Нийтийн эрх зүйн хуулийн этгээд санал болгосноор);
 - “Цахим аялал жуулчлалын холбоо” ТББ-ын тэргүүн (Нийтийн эрх зүйн хуулийн этгээд санал болгосноор);

-“Монголын аялал жуулчлалын холбоо”-ны
ерөнхийлөгч;

-“Түгээмэл хөгжил” төвийн тэргүүн
(тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга.

---o0o---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Боловсролын сайд
- Гишүүд:
- Сангийн сайд;
 - Батлан хамгаалахын сайд;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
 - Эрүүл мэндийн сайд;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Боловсрол, шинжлэх ухаан, технологийн бодлогын зөвлөх;
 - Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
 - Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга;
 - Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухааны Бага чуулганы дарга;
 - “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-ын захирал;
 - Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирал;
 - Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч;
 - Монголын багш нарын холбооны тэргүүн;
 - Монгол Улсын их сургуулийн ректор;
 - Монгол Улсын Боловсролын их сургуулийн ректор;
 - Монголын их, дээд сургуулиудын консорциумын ерөнхийлөгч;

-Мэргэжлийн болон техникийн боловсролын хувийн сургуулиудын холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Монголын оюутны холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын сурагчдын холбооны гүйцэтгэх захирал;

-“Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний зөвлөлийн тэргүүн (тохиролцсоноор);

-“Боловсролын реформ хөдөлгөөн” ТББ-ын тэргүүн;

-“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо”-ны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-“Монголын Аутизмын холбоо”-ны зөвлөх (тохиролцсоноор);

-Боловсрол судлаач (тохиролцсоноор);

-Боловсролын технологи судлаач (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Боловсролын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга.



Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/
- Дэд дарга: -Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга;
- Гишүүд: -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
- Зам, тээврийн сайд;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
- Эрчим хүчний сайд;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр);
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга /төсөл, хөтөлбөр хариуцсан/;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;


-Бүсийн зөвлөлийн дарга нар;

-Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимийн ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр).

Нарийн бичгийн дарга:

-Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/-ын ахлах зөвлөх.

---oOo---



Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 6 дугаар хавсралт

ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Сангийн сайд
- Гишүүд: -Гадаад харилцааны сайд;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Гаалийн ерөнхий газрын дарга;
- Татварын ерөнхий газрын дарга;
- Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал;
- Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал;
- Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга;
- Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;

-Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга;

-Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);


-Монгол Улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн захирал;

-“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах форум”-ын зохицуулагч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:

-Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга.

---oOo---



Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга: -Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/
- Гишүүд:
- Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга;
 - Гадаад харилцааны сайд;
 - Сангийн сайд;
 - Хууль зүй, дотоод хэргийн сайд;
 - Батлан хамгаалахын сайд;
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
 - Боловсролын сайд;
 - Зам, тээврийн сайд;
 - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
 - Эрчим хүчний сайд;
 - Эрүүл мэндийн сайд;
 - Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
 - Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/-ын ахлах зөвлөх;

- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
 - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал;
 - Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга;
 - Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);
 - Монголын улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор).
- Нарийн бичгийн дарга: -Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга.

---oOo---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 8 дугаар хавсралт

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Гишүүд: -Авлигатай тэмцэх газрын дарга (зөвшилцсөнөөр);
- Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн шүүгч (зөвшилцсөнөөр);
- Улсын ерөнхий прокурорын орлогч (зөвшилцсөнөөр);
- Ерөнхий аудиторын орлогч (зөвшилцсөнөөр);
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга (зөвшилцсөнөөр);
- Сангийн сайд;
- Батлан хамгаалахын сайд;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
- Боловсролын сайд;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Зам, тээврийн сайд;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
- Эрүүл мэндийн сайд;
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга /төсөл, хөтөлбөр хариуцсан/;

- Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал;
- Тагнуулын ерөнхий газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- Хил хамгаалах ерөнхий газрын дарга;
- Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга;
- Гаалийн ерөнхий газрын дарга;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга;
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга;
- Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын дарга;
- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга;
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал;
- Хууль зүйн туслалцааны төвийн захирал;
- Дотоод хэргийн их сургуулийн захирал;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал (тохиролцсоноор);
- Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын криминологичдын холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор).
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

Нарийн бичгийн
дарга:

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 9 дүгээр хавсралт

ДОПИНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ (ПЛАТФОРМ)-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН


- Дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Гишүүд:
- Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/-ын ахлах зөвлөх;
 - Биеийн тамир, спортын улсын хорооны дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
 - Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга;
 - Авлигатай тэмцэх газрын Гүйцэтгэх ажлын хэлтсийн орлогч бөгөөд албаны дарга;
 - Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга;
 - Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга;
 - Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүний эмийн зөвлөлийн гишүүн (тохиролцсоноор);
 - Монголын Үндэсний олимпын хорооны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
 - Монголын Үндэсний Паралимпын хорооны Удирдах зөвлөлийн гишүүн (тохиролцсоноор);

-Монголын Үндэсний допингийн эсрэг
байгууллагын гүйцэтгэх захирал
(тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого
төлөвлөлтийн газрын дарга.

---o0o---



Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт

ДЭЛХИЙН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Гишүүд:
- Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал;
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
 - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
 - ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга;
 - Соёл, урлагийн газрын Соёл, соёлын өвийн хэлтсийн дарга;
 - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Кадастрын хэлтсийн дарга;
 - Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал;
 - Соёлын өвийн үндэсний төвийн захирал;
 - Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал;

-Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн захирал;

-Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнгийн захирал;

-Байгаль хамгааллын судалгаа, хөгжлийн төвийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Хөшөө дурсгал, дурсгалт газрын Олон улсын зөвлөлийн Монголын хорооны дарга (тохиролцсоноор).


Нарийн бичгийн дарга:

-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн;

-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн;

-ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссын Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн.

---oOo---



Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд;
- Дэд дарга: -Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Гишүүд:
- Сонгуулийн ерөнхий хорооны дарга (зөвшилцсөнөөр);
 - Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр);
 - Хүний эрхийн үндэсний комиссын дарга (зөвшилцсөнөөр);
 - Төрийн албаны зөвлөлийн гишүүн (зөвшилцсөнөөр);
 - Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
 - Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга /Засгийн газрын хүний нөөцийн асуудал хариуцсан/;
- Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр);
- Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга;
- Нийслэлийн Засаг даргын орлогч;
- Удирдлагын академийн захирал;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал (тохиролцсоноор);
- Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын эрэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны Хөгжлийн бодлогын газрын дарга (тохиролцсоноор);
- Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Ерөнхий зохицуулалтын газрын дарга (тохиролцсоноор);
- Социал Демократ-Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-“Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-ны тэргүүн (тохиролцсоноор);

-Хэвлэлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-Монголын нутгийн удирдлагын холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал (тохиролцсоноор);

-“Гал голомт” үндэсний хөдөлгөөний тэргүүн (тохиролцсоноор);

-Хараат бус судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-“МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээний зохицуулагч (тохиролцсоноор);


-Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн ахлагч;

-Жендэрийн асуудлаарх эрдэмтэн, судлаачдын бүлгийн ахлагч.

Нарийн бичгийн дарга:

-Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны дарга.

---o0o---



Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 12 дугаар хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Гишүүд: -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
- Сангийн сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- Батлан хамгаалахын сайд;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
- Боловсролын сайд;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
- Эрүүл мэндийн сайд;
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр);
- Монголбанкны дэд ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр);
- Биеийн тамир, спортын улсын хорооны дарга;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал (тохиролцсоноор);
- “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал;

- Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын сагсан бөмбөгийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын хөл бөмбөгийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын оюутны холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын залуучуудын эвслийн зохицуулагч (тохиролцсоноор);
- “Түгээмэл хөгжил” төвийн тэргүүн (тохиролцсоноор);
- “Жэй Си Ай Монгол” байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор);
- Монголын залуу эрдэмтдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Залуучуудын зохистой хөдөлмөрийн үндэсний сүлжээний зохицуулагч (тохиролцсоноор);
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн суурин төлөөлөгч (тохиролцсоноор);
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн Ажлын
албаны дарга.

---o0o---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 13 дугаар хавсралт

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга: -Зам, тээврийн сайд
- Гишүүд:
- Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн сайд;
 - Боловсролын сайд;
 - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
 - Эрүүл мэндийн сайд;
 - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;
 - Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
 - Цагдаагийн ерөнхий газрын дарга;
 - Тээврийн цагдаагийн албаны дарга;
 - Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал;
 - Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
 - Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
 - “Түгээмэл хөгжил” төвийн тэргүүн;
 - “Эвт гурван тулга” төрийн бус байгууллагын тэргүүн (тохиролцсоноор).
- Нарийн бичгийн дарга: -Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга.

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 14 дүгээр хавсралт

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга: -Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
-Тагнуулын ерөнхий газрын дарга.
- Гишүүд: -Хүний эрхийн үндэсний комиссын дарга (зөвшилцсөнөөр);
-Монголбанкны дэд Ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр);
-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр);
-Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ;
-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Цахим засаглал, мэдээлэл, технологийн газрын дарга;
-Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга;
-Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга (зөвшилцсөнөөр);
-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;
-Зэвсэгт хүчний Жанжин штабын Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч;

-Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга;

-Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга;

-Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ-ын захирал;

-“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн захирал.

Нарийн бичгийн дарга:

-Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга.

---o0o---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 15 дугаар хавсралт

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС
ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭДДЭХҮҮН

- Дарга: -Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Гишүүд: -Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
-Боловсролын сайд;
-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
-Эрүүл мэндийн сайд;
-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга;
-Гаалийн ерөнхий газрын дарга;
-Цагдаагийн ерөнхий газрын дарга;
-Тагнуулын ерөнхий газрын дарга;
-Хил хамгаалах ерөнхий газрын дарга;
-Гадаадын иргэн, харьяатын газрын дарга;
-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга;
-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга;
-Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга;
-Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын дарга;

-Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал;

-Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал.

Нарийн бичгийн
дарга:

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

---o0o---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07 ны өдрийн 21 дүгээр тогтоолын 16 дугаар хавсралт


МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛС ДАХЬ СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЛИЙН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН 5485449

- Дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Дэд дарга: -Гадаад харилцааны сайд
- Гишүүд:
- Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
 - Монгол Улсын Шадар сайд /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/;
 - Сангийн сайд;
 - Хууль зүй, дотоод хэргийн сайд;
 - Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд;
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
 - Зам, тээврийн сайд;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга;
 - Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга;
 - Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал;
 - МОНЦАМЭ агентлагийн захирал (зөвшилцсөнөөр);
 - “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-ын гүйцэтгэх захирал.
- Нарийн бичгийн дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Гадаад харилцаа, олон улсын мэдээлэл сурталчилгаа, хамтын ажиллагааны газрын дарга

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 17 дугаар хавсралт

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

- Дарга: -Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Дэд дарга: -Тагнуулын ерөнхий газрын дарга
- Гишүүд: -Сангийн сайд;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга;
- Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр);
- Улсын ерөнхий прокурорын орлогч (зөвшилцсөнөөр);
- Авлигатай тэмцэх газрын дэд дарга (зөвшилцсөнөөр);
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);
- Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал;
- Гаалийн ерөнхий газрын дарга;
- Татварын ерөнхий газрын дарга;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга (тохиролцсоноор);
- Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;
- Нарийн бичгийн дарга: -Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга.



Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 18 дугаар хавсралт

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд
- Дэд дарга: Эрүүл мэндийн сайд
- Гишүүд:
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Нийгмийн бодлого, эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх (зөвшилцсөнөөр);
 - Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн газрын дарга;
 - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
 - Үндэсний статистикийн хорооны дарга; (зөвшилцсөнөөр);

-Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал;

-Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн;

-Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал;

-Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны дарга;

-Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Монголын улаан загалмай нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн даргын орлогч (тохиролцсоноор);

-Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн ерөнхий захирал.

Нарийн бичгийн
дарга:

-Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга.

---o0o---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 19 дүгээр хавсралт

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Гишүүд: -Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны дарга;
